



МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ САНХҮҮГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ


Б. Даажамба

ЭСЯ-ны худалдаа, эдийн засгийн асуудал эрхэлсэн зөвлөх
 MSc in Public Affairs, BA in Finance, Докторант (DBA)

Монгол Улсын санхүү, эдийн засгийн өнөөгийн байдлыг та бүхэнд товч мэдээлж, үүссэн бий болсон хямралыг даван туулах талаар Засгийн газраас богино болон дунд хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулья.



Агуулга / Contents

1. Санхүү, эдийн засгийн нөхцөл байдал
(Economic background)
2. Дунд хугацаанд хэрэгжүүлэх болон хямралыг даван туулах ойрын хугацааны бодлогын арга хэмжээ
 - Дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ
 - Хямралыг даван туулах ойрын хугацааны бодлогын арга хэмжээ*(GoM medium-term policies)*
3. Санал





Олон улсын санхүүгийн зах зээлийн хямралын уршгаар дэлхийн томоохон орнуудад эдийн засгийн уналт бий болж, цаашид таамаглах аргагүй хэмжээгээр үргэлжилж байна. Энэхүү хямрал нь тэдгээр орны бодит эдийн засагт хүчтэй нөлөөлж, цаашид дэлхий нийтийг хамарсан худалдаа, аж үйлдвэр, санхүүгийн зах зээлийн хямрал болж өргөжих хандлагатай байгаа юм. АНУ, Европын холбооны улсуудын санхүүгийн салбарын уналт нь эдийн засгийн энэхүү хямралын гол шалтгаан болж, улмаар олон сувгаар дамжин хөгжиж буй орнуудад нөлөөлж байна.

Дэлхийн санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгө /хувьцаа, бонд, валютын үнэлгээ/ ойролцоогоор 50 триллион ам.доллараар буурч байгаа нь дэлхийн ДНБ-тэй тэнцэх хэмжээнд хүрч байна.



Дэлхийн эдийн засгийн уналт нь мөнгө санхүүгийн бусад эрсдэлийг дагуулж байна. Дэлхийн улс орнууд үндэсний үйлдвэрлэлээ дэмжихийн тулд татварын орчноо өөрчлөх замаар дотоодын үйлдвэрлэгчдээ хамгаалах болсны улмаас гадаад худалдааны эргэлтийг тодорхой хэмжээгээр сулрахад хүрч байна. Мөн дэлхий нийтийн дефляцийн дарамт нь эдийн засгийг сэргээхэд бодитойгоор хүндрэл учруулж байна.





Санхүүгийн хямрал даамжирч эдийн засгийн хүрээг хамрах болсноор дэлхийн нийт хэрэглээ буурч, үйлдвэрлэгч орнуудын үйлдвэрлэл, экспорт багасан, үйлдвэрлэлийн түүхий эдийн үнэ огцом унаж байна. Түүнчлэн, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах хандлагатай болж байна.

Дэлхийн томоохон эдийн засгууд хумигдаж байгаатай уялдан гадаад худалдааны эргэлт багасч бараа бүтээгдэхүүний экспорт буурч байна. Өндөр хөгжилтэй, гадаадаас ажиллах хүч олноор авдаг улсуудын эдийн засаг хямарсны улмаас тухайн улсад ажиллаж буй гэрээт ажиллагсдын тоо, орлого буурч, улмаар хөгжиж буй орнууд руу чиглэсэн санхүүгийн шилжүүлэг багасч байна. Энэ нь санхүүгийн эх үүсвэрийн үнэ цэнийг ихээхэн өсгөж байгаа болно.

Санхүүгийн хямралаас эдийн засгийн хямрал руу шилжсэнээр дэлхийн нийт хэрэглээ буурч үйлдвэрлэгч орнуудын үйлдвэрлэл, экспортын хэмжээ багасч түүхий эдийн үнэ огцом унасан. 2008 оны дунд үеэс эхлэн Монголын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн зэс, нүүрс, зэрэг бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр огцом унаж эхэлсэн. Ялангуяа зэсийн үнэ 2008 оны 4 дүгээр сард нэг тонн нь 8685 ам.доллар байснаа 2009 оны 2 дугаар сардын эцэст 3313 ам.доллар болж 62 хувиар буурсан.

Улс орнуудын эдийн засаг хямралд орсноор АНУ-ын доллартай харьцах хэмжээгээр бусад орнуудын валютууд унаж эхэлсэн бөгөөд валют хоорондын тогтвортой байдал алдагдаж, валютыг орлох илүү найдвартай альтернатив эх үүсвэр болох алтны үнэ өсч байна. Өөрчлөгдөж байгаа энэхүү нөхцөл байдалд тохирсон бодлогын өөрчлөлтийг улс орнууд авч хэрэгжүүлж эхлээд байна.

Дэлхийн зах зээл дээрхи түүхий эдийн үнэ унаснаар Монгол Улсын төсвийн орлогын голлох хувийг бүрдүүлдэг түүхий эдээс олох татварын орлого буурч, экспортоос орж ирэх гадаад валютын хэмжээ багассан зэргээс шалтгаалан Монгол Улсад санхүүгийн хямрал мэдрэгдэж эхэлсэн.




2006 онд 106,9 сая ам.долларын ашигтай гарч байсан гадаад худалдааны тэнцэл 2007 онд -114,3, 2008 онд -715,6 сая ам.долларын алдагдалтай гарсан. Үүнд экспортын барааны дэлхийн зах зээлийн үнийн уналт нөлөөлсөн. Энэхүү алдагдлын хэмжээгээр Засгийн газарт болон бизнесийн салбарт гадаад валютын хомсдол буй болсон.

Харин 2009 оны эхний 2 сарын байдлаар гадаад худалдааны баланс ашигтай гарлаа. 2009 оны эхний 2 сарын дүнгээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 438.2 сая ам.доллар, 2008 оны мөн үеэс 371.4 сая ам.доллар буюу 45.9 хувиар буурчээ. Экспорт нь импортоос 26.5 сая ам.доллараар давсан үзүүлэлттэй гарлаа.

Монгол Улсын гадаад худалдааны голлох түнш улсуудын эдийн засгийн өсөлт буурснаар эдгээр орны хэрэглээ багасах төлөвтэй байгаа нь манай улсын гадаад худалдаа, экспорт буурахад нөлөөлж байна. Дэлхийн зах зээлийн хямрал, түүхий эд бараа, бүтээгдэхүүн, зэсийн үнийн уналттай давхцан гадаад валютын нөөц буурч эхэлснээр Монголбанкны зүгээс төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг тогтвортой барихад хүндрэл үүсч эхэлсэн. Гадаад валютын нөөц багасч төгрөгийн ханш суларснаар бусад улс орнуудын адил гадаад валютын хүндрэл, хямрал үүсч эхэлсэн.

Хэдийгээр уул уурхайн салбараас орох орлогын хэмжээ буурсан ч, төсвийн зарлага хэвээр үргэлжилснээс шалтгаалан төсвийн алдагдал нэмэгдсэн.



Эдийн засгийн өсөлтийн жилүүдэд төсөв нь уул уурхайн салбараас хэт хамааралтай болсон. Хэдийгээр төсөв өсөлтийн жилүүдэд ашигтай гарч байсан ч энэ нь өнөөгийн хямралыг даван туулахад хангалттай байж чадсангүй. Уул уурхайгаас бусад салбаруудын байдал түүхий эдийн үнийн хэт өсөлттэй жилүүдэд муудсан. Одоо эдгээр алдааг залруулах шаардлагатай болоод байна.

Зах зээлийн эдийн засагт шилжиж, банкны салбарын үйл ажиллагаа тогтворжиж эхэлснээс хойш 10 гаруй жилийн хугацаанд 20-30 жилийн урт хугацаатай хадгаламж бий болж чадаагүй нь санхүүгийн салбарын нэг гол дутагдалтай тал байсаар байна. Банкны салбар дахь иргэдийн итгэл суларсны улмаас 2008 оны 11 дүгээр сараас эхэлж хадгаламж таталт хүчтэй явагдаж эхэлсэн. Засгийн газар шуурхай ажиллаж 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хадгаламжид баталгаа гаргах хуулийг боловсруулан УИХ-аар батлуулсан. Засгийн газар хадгаламжид баталгаа гаргаснаар иргэд, байгууллагын хадгаламж таталтыг багасгаж чадсан боловч тухайн үед төгрөгийн ханшны сулралт явагдаж байсны улмаас гадаад валютын хадгаламж нэмэгдэхэд хүргэсэн юм.

Монгол улсын эдийн засаг 2005 оноос эхлэн харьцангуй өндөр хурдтай өсч эхэлсэн бөгөөд 2007 онд 10,2 хувьд хүрч байсан бол 2008 оноос өсөлтийн хурд буурч 8,9 хувьд хүрсэн. Эдийн засгийн өсөлтийг 2009 онд 2,75 хувь, 2010 онд 4,7 хувь байна гэж тооцооллоо.

Дэлхийн зах зээлийн нефть, хүнс, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт болон эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэний улмаас 2008 онд 34 хувь хүрч өсч байсан инфляци 2009 он гарсаар аажмаар буурч байна. Монгол Улсын инфляцийн 9 хувьд байна гэж тооцсон. Эдийн засаг цаашид хүндэрч хэрэглээ эрс багасвал бараа бүтээгдэхүүний үнэ буурч, улмаар дефляцид орох сөрөг үр дагавартайг бид ойлгож байгаа.

Эдийн засаг, санхүүгийн хямралаас Монгол Улс хохирол багатай гарах, цаашид эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгахад чиглэсэн төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хямралын эсрэг төлөвлөгөөг үе шаттайгаар батлан мөрдөж ажиллаж байна.

Хямралын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ – I шат

<p>Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> • Хямралаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө 2 үе шаттай <ul style="list-style-type: none"> - I үе шатын төлөвлөгөө - 2008.11.05 /Засгийн газрын 28 дугаар тогтоол/ Зорилт: Олон улсын санхүүгийн зах зээлийн хямралаас шалтгаалан Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарч болгоомжгүй хүндэрхээс сэргийлэх болон түүсний мөхөөр байдалд зохицуулах арга арга хэмжээ - II үе шатын төлөвлөгөө 2009.03.09 /УИХ-ын тогтоол 22 дугаар тогтоол/ Зорилт: Дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой сурьт бүрдүүлэх - III үе шатын төлөвлөгөө 2009.03.14 /ОУВС-ийн дэмжлэгтэйг эргэ/ Зорилт: Монгол Улсын санхүүгийн тогтвортой хөгжлийн дэвж туслах

- Банкнд дахь мөнгөн хадгаламжинд баталгаа гаргах тухай хуулийг баталсан.
- Банк санхүүгийн салбарын шаардлагатай хуулийн төслүүдийг УИХ-р яаралтай батлуулахаар ажиллаж байна.
- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төлсийг боловсруулж батлуулсан.
- Монгол Улсын экспортын голлох түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийн хандлагад дүгнэлт хийж төсвийн орлогыг тооцооллоо.
- Арилжааны банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих

хүрээнд санхүүгийн эх үүсвэрийг арилжааны банкуудад байршууллаа.

- Арилжааны банкуудын зүгээс гадаадын зах зээлээс хөрөнгө татах асуудлыг дэмжих, энэ хүрээнд засгийн газраас баталгаа гаргах, Төв банкнаас дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна.
- ОХУ, БНХАУ болон хамтран ажилладаг олон улсын банк, санхүүгийн байгууллагаас хөнгөлттэй зээл, тусламж авах талаар хамтран ажиллаж байна.

Хямралын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ – II шат

- Түр хороо: Ерөнхий сайд, Шадар сайдууд, Сайд нар, Төв банкны ерөнхийлөгч
- Ажлын хэсэг: Сангийн дэд сайд, бусад яамдын ТНБД, газрын дарга нар

Тавигдаж буй зорилгууд:

- Атрын 3 дахь аяны хүрээнд хаврын тариалалтыг явуулж, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах
- Үйлдвэрлэлийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, шинээр бий болгох, ЖДҮ-ийг хөгжүүлэх
- 100 мянган айлын орон сууцны хөтөлбөрийг эрчимжүүлэх, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх
- Эрчим хүчний сүлжээний аюулгүй, найдвартай байдлыг хангах
- Уул уурхайн салбарыг дэмжиж экспортын орлогыг нэмэгдүүлэх ... г.м.

Засгийн газраас дунд хугацаанд хэрэгжүүлэх болон ойрын хугацаанд хямралыг даван туулах бодлогын арга хэмжээг тодорхойлоод байна. Дунд хугацааны бодлого нь дараахь 4 салбар тус бүрээр 2011 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тусгасан болно.

<p>2. ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ</p> <p>I ТӨСВИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД</p> <p>II НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРЭЭНД</p> <p>III УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД</p> <p>IV. БАНКНЫ САЛБАРЫН ХҮРЭЭНД</p>
<p>I ТӨСВИЙН БОДЛОГО (үргэлжлэл)</p> <p>✓ Төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлийг сайжруулах зорилтын хүрээнд:</p> <p>2009 онд</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох; • Техник, эдийн засгийн үндэслэлгүй төслүүдийг санхүүжүүлэхгүй байх, <p>2010-2011 онд</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулан батлах; • Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгох тогтолцоог боловсронгуй болгох.

<p>I ТӨСВИЙН БОДЛОГО</p> <p>✓ Төсвийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд:</p> <p>2009 онд</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн хариуцаагын тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн барих. <p>2010-2011 онд</p> <ul style="list-style-type: none"> • 2010 оны төсвийг батлагдсан тоон хязгаарт нь барих; • Нэгдсэн төсвийн тухай шинэ хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн барих. <p>✓ Уул уурхайн салбарын орлогын удирдлагыг сайжруулах зорилтын хүрээнд:</p> <p>2009 онд</p> <ul style="list-style-type: none"> • Уул уурхайн салбарын орлогын менежментийн хувилбаруудыг боловсруулан УИХ-аар хэлэлцүүлэх.
<p>I ТӨСВИЙН БОДЛОГО (үргэлжлэл)</p> <p>✓ Дэд бүтцийн салбарын их засварын зардлыг төсөвт тусгах:</p> <p>2009-2011 онд</p> <ul style="list-style-type: none"> • Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд бүтцийн салбарын их засварын арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлж, 2010, 2011 оны төсөвт энэ чиглэлд их засварын зарлын доод хязгаарыг тогтоож тусгах.

Төсвийн тогтвортой байдлыг хангахын тулд төсөв зохиох, хэрэгжүүлэх ажлыг шинэ шатанд гаргах, төсвийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгох, төсвийн сахилга батыг сайжруулах, улсын төсвийн хариуцлагын тухай хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх, батлагдсан төсвийг тоон хязгаарт нь барьж ажиллахаар төлөвлөж байна. Энэхүү ажлын хүрээнд уул уурхайн салбарын орлогын удирдлагыг сайжруулах, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох асуудлыг мөн хамруулж байгаа юм. Үүнтэй уялдан, төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлэх, дунд хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй болох явдал чухал байна.

Нийгмийн халамжийн бодлогыг оновчтой болгох, нийгмийн хамгаалалд хамгийн эмзэг хэсгийг хамруулах зорилтын хүрээнд одоо хэрэгжиж буй нийгмийн халамжийн олон тооны хөтөлбөрүүдийг нэгтгэх, хүүхдийн мөнгө олголтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулах, амьжиргааны доод түвшинг дахин шинчлэн тогтоох, нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдагсдын мэдээллийн санг бий болгох, халамжийн хөтөлбөрт хамрагдагсдын амьжиргааны түвшингийн өөрчлөлтийг тодорхойлох арга зүйг бий болгох зэрэг арга хэмжээг авна.

II. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

✓ *Нийгмийн хамгаалалд хамрагдаагүй иргэдийг хамраас хамгаалах зорилтын хүрээнд:*

2009 онд:

- Төсвийн тодотгоор төсвийн зардыг оновчтой болгох чиглэл баримталах;
- Одоогийн нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг нэгтгэх, үүнд одоо амьжиргааны доод түвшинд амьдарч буй орхын 60%-ийг хамруулах;
- Хүүхдийн мөнгө олгох хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулах;
- Амьжиргааны доод түвшинг дахин тогтоох;
- Нийгмийн халамжийн мэдээллийн санг бий болгох;
- Халамжийн хөтөлбөрт хамрагдагсдын амьжиргааны түвшингийн өөрчлөлтийг тодорхойлох арга зүйг бий болгох.

II. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ (үргэлжлэл)

2010 онд:

Төсвийн зардыг бууруулах:

- 2009 онд шинэчлэн тогтоосон амьжиргааны доод түвшингийн үзүүлэлтэд хамрагдах орхын 40%-ийг нийгмийн халамжийн хөтөлбөрт хамруулах;
- Халамжийн хөтөлбөрт хамрагдагсдын амьжиргааны түвшингийн өөрчлөлтийг тооцох судалгаа явуулах.

2011 онд:

Төсвийн зардыг бууруулах:

- Нийгмийн халамжийн хөтөлбөрт зөвхөн нэн ядуу орхынг хамруулах;
- Халамжийн хөтөлбөрт хамрагдагсдын амьжиргааны түвшингийн өөрчлөлтийг засийн байдалаар тодорхойлох.

Дунд хугацаанд уул уурхайн салбарын бодлогыг цогцоор нь сайжруулах эрх зүй, эдийн засгийн орчинг бүрдүүлэх зорилт тавьж байна.

III. УУЛ УУРХАЙН САЛБАР

✓ *Уул уурхайн салбарын хууль, эрх зүйн орчин, тус салбарт баримтлах төсвийн бэлэн салбарын бодлогыг цогцоор нь боловсронгуй болгох.*

2009 онд:

- ОТ гэрээний дагуу уул уурхайн салбарын бодлогыг тодорхой болгох;
- Хөрөнгө оруулалтын гэрээний загварын төслийг боловсруулах, мөрдөж ажиллах;
- Кадастрын албаны журмыг Засгийн газраар батлуулж, мөрдөж ажиллах.

III. УУЛ УУРХАЙН САЛБАР (үргэлжлэл)

2010 онд:

- Хөрөнгө оруулалтын гэрээний загварыг уул уурхайн шинэ төслүүдэд ашиглах;
- Засгийн газраас батлагдсан журмын дагуу кадастрын үйл ажиллагааг явуулах.

2011 онд:

- Уул уурхайн компаниудын хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх;
- Ашигт малтмалын салбарт мониторинг, хяналтыг оновчтой болгох.

Тухайлбал:

- Оюутолгой гэрээний дагуу Уул уурхайн салбарын бодлогыг тодорхойлох
- Уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээний загварын төслийг боловсруулах, мөрдөж ажиллах
- Кадастрын албаны журмыг Засгийн газраар батлуулж, мөрдөж ажиллах
- Ашигт малтмалын татварыг (гэнэтийн ашгийн татвар) хянаж үзэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх юм.

III. УУЛ УУРХАЙН САЛБАР (үргэлжлэл)

✓ *Уул уурхайн салбар дахь Монгол ажигчдын тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:*

2009 онд:

- Ажиллах хүчнийг дадлагажуулах төлөвлөгөөг боловсруулагдаж, хандивлагчдын санхүүжилт хийгдсэн байх;
- Тодорхой хэмжээний Монгол ажигчид уул уурхайн чиглэлээр дадлагажсан байх.

2010-2011 онд:

- Тодорхой хэмжээний Монгол ажигчид уул уурхайн чиглэлээр дадлагажсан байх.

Дунд хугацаанд хөрөнгө оруулалтын гэрээний загварыг улам боловсронгуй болгон уул уурхайн шинэ төслүүдэд ашиглах, уул уурхайн компаниудын хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх, энэ салбарт ажиллах дотоодын ажиллах хүчний мэргэшил боловсролыг дээшлүүлэх, нэмэлт ажлын байр бий болгох ажлууд хийгдэх болно.

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах хүрээнд 2009 онд

- Банкны аудит, хяналт, шалгалтыг сайжруулах
- Банкны салбарт бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Системийн тогтвортой байдлыг хангах, оновчтой удирдлагын

тогтолцоог нэвтрүүлэх, эрсдлийн удирдлагыг сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

IV. БАНКНЫ САЛБАР

✓ *Банкны салбарын тогтвортой байдлыг хангах*

2009 онд:

- Олон улсын аудитын компаниар Анод банкнд хөндлөнгийн хяналт хийлгэх, бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Банкны хяналт шалгалтыг сайжруулах;
- Системийн тогтвортой байдлыг хангах, оновчтой удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, эрсдлийн удирдлагыг сайжруулах;
- 2012 оны 1 дүгээр сарын 1-ний дотор банкуудын дүрмийн санг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх;
- Төв банк, арилжааны банк хоорондын төлбөр тооцооны механизмийг боловсронгуй болгох.

IV. БАНКНЫ САЛБАР (үргэлжлэл)

✓ *Банкны салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:*

- Эзэл найдавгүй болсон тохиолдолд барьцаа хөрөнгийн үл мөргөх журмаар банкуудад шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж;
- Банкийг татан буулгах, худалдах, нийлүүлэх үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх.

Мөн Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг дэмжих, чадавхижуулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд банк санхүүгийн салбарын шаардлагатай 13 хуулийн төслийг яаралтай боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. Тухайлбал, Төв банк, Банкны тухай, Валют зохицуулалтын тухай.

Та бүхэнд Засгийн газрын зүгээс дунд хугацаанд авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг танилцууллаа. Дээр дурдсан арга хэмжээнүүд нь Засгийн газраас дунд хугацаанд авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүд бөгөөд үүнээс бид ойрын хугацаанд дараахь бүлэг асуудлуудыг ОУВСангийн дэмжлэгтэй хөтөлбөр болгон томъёолсон бөгөөд ОУВСангийн Захирлуудын зөвлөлөөр батлагдана гэж найдаж байгаа юм.

Богино хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

/18 сарын хугацаанд/

Засгийн газрын богино хугацааны хөтөлбөр

Зорилго:

- Засгийн газрын санхүүгийн байдлыг эрүүлжүүлэх,
- Ханшийг дохистой тэнцвэрт хүргэн тохируулах, гадаад валютын нөөцийг хамгаалах,
- Банкны системд итгэх итгэлийг сайжруулах,
- Эдийн засгийн шинэтгэлийн явцад нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах.

- Хотолборийн хугацаа - 18 сар
- Хотолборийн дүн - 224 сая ам.доллар
- Эргэн төсөөллийн хугацаа - 4 жил

(Чөлөөт хэв 2 жилийн төлбөр)

- Төсвийн алдагдлыг нөхөхөд зориулан шаардагдаж буй эх үүсвэр:
2009 онд 145 сая ам.доллар
2010 онд 60 сая ам.доллар

Засгийн газрын энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын төлбөрийн балансыг дэмжих, төсвийн алдагдлыг бууруулахад чиглэсэн.

БОГИНО ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН БҮТЭЦ

- Төсвийн бодлогын хүрээнд;
- Мөнгөний бодлого, валютын ханшны хүрээнд;
- Банкны салбарын хүрээнд;
- Макро эдийн засгийн хүрэх үр дүнд;

МӨНГӨНИЙ БОДЛОГО, ВАЛЮТЫН ХАНШНЫ БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- Валютын ханшийн уян хатан бодлого баримтлах;
- Гадаад валютын нөөцийг хамгаалах;
- Гадаад валютын арилжааны зохион байгуулалтыг шинэчлэх;
- Төв банкны бодлогын хэрэгслийг боловсронгуй болгох.

Хөтөлбөрийг нийт 18 сарын хугацаатай хэрэгжүүлэх бөгөөд богино хугацаанд мөнгөний, төсвийн болон бусад бодлогын арга хэмжээг уялдаатай авч хэрэгжүүлэх замаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангахаар төлөвлөж байна. Эдгээр багц арга хэмжээг хэрэгжүүлэх, төлбөрийн балансыг дэмжихэд зориулан ОУВС-аас 224 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл авахаар хүсэлт гаргаад байна.

Энэхүү хөтөлбөрийг дараахь дөрвөн салбарын хүрээнд голлон хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.

Төсвийн алдагдлыг бууруулах зорилтын хүрээнд

- төсвийн зарлагыг ДНБ-ий 5 хувьтай тэнцэх хэмжээгээр бууруулах;
- АХБ, Дэлхийн банктай хамтран нийгмийн халамжийн тогтолцоог шинэчлэх бодлого хэрэгжүүлэх;
- Төсвийн хариуцлагын тухай шинэ хуулийг УИХ-д өргөн барих;
- Оюутолгой, Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээний асуудлыг шийдвэрлэх зэрэг зорилтуудыг шийдэх зэрэг арга хэмжээ авах болно.

ТӨСВИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- Төсвийн алдагдлыг 2009 онд ДНБ-ий 6 хувь, 2010 онд 4 хувь байлгах;
– Төсвийн зарлагыг бууруулах;
– Төсвийн орлогыг нэмэгдүүлэх;
- АХБ, Дэлхийн банктай хамтран нийгмийн халамжийн тогтолцоог шинэчлэх;
- Төсвийн хариуцлагын тогтолцооны эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- Уул уурхайн томоохон ордуудын хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах.

БАНКНЫ САЛБАРЫН ХҮРЭЭНД

- Банкн дахь иргэдийн итгэлийг сайжруулах;
- Банкны салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах;
- Банкны салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох.

Дунд хугацаанд валютын ханшийн уян хатан бодлого баримталж, гадаад валютын нөөцийг хамгаалах, гадаад валютын арилжааг Төв банкны валютын захаас авдаг зохион байгуулалтыг нэвтрүүлэх, Төв банкны үнэт цаасыг 2009 оны II хагасаас эхлэн 3 сарын хугацаатайгаар гаргадаг болох, хүүг санхүүгийн зах зээлийн нөхцөлтэй уялдуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

- Эдийн засгийн өсөлт - 2.75 хувиас бууруулахгүй
- Инфляцийг түвшин - нэг оронтой тоонд барих
- Төсвийн алдагдал - ДНБ-ий 6 хувиас хэтрүүлэхгүй
- Эдийн засгийн өсөлт - 2010 онд 4.25 хувьд хүргэх.

БОГИНО ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ШАДГУУР НӨХЦӨЛӨД	АРГА ХЭМЖЭЭ
1. 2009 оны төсвийн тооцоог хайх.	Төсвийн батлагдсан (2009.03.13)
2. АНУД банкны олон улсын дунд хайгаж	Саям үсвэр ир хүртэл эдийн засгийн төлөвлөгөө
3. Мөнгө халамжийн багцааг гаргасан хууль зарим өөрчлөлттэй оруулах	Хуулийн шинэчлэлт төсөл 2009.03.05-ны батлагдсан
4. Хувицаа нь хугарсан оройн талаар гадаад нэхлүүдэгч нэртэй салбар төгсөө, шийдвэрлэх	Хөтөлбөр тайлбарыг ОУВС-д тусуулах
5. Монголбанкны валютын арилжааг дуулига худалдаа хэлбэрээр оруулах механизмд шинэчлэх.	Судалга хийгдэж байна.
6. Эргэн түүгээс УИХ-аас авах хайгаж татварыг төгрөгөөр авдаг болгох хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх.	Татварын өрхний хууль татварыг төгрөгөөр төлжэж болно хайгаж оруулах, батлагдсан
7. Банк хоорондын гадаад валютын арилжааг дэлгэц ашиглан оруулах механизм бүрдүүлж авах.	Судалга байгаа.
8. Аудитын дүнгээг үзэхийн ОУВС-тай зөвшөөрж АНУД банкны бүтцийг өөрчлөх	Аудитын дүнгээг үзэхийн төсөл
9. Халамжийн хөтөлбөрийн хяналт үзэх.	Хяналт үзэж байна
10. Банк санхүүгийн хөтөлбөрийг хуулиар УИХ-р хэлэлцүүлэх	Хайгдэж байна
11. Төсвийн хариуцлагын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барих	Хуулийн төсөл боловсруулж байна

Цаашид банкны салбарт бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, чадавхийг сайжруулах, системийн тогтвортой байдлыг хангаж ажилласнаар иргэдийн итгэлийг сэргээх бололцоотой гэж үзэж байна. Банкны салбарын хяналт, шалгалтыг сайжруулах, хууль, эрхзүйн орчинг боловсронгуй болгох шаардлагыг үндэслэн Банкны тухай болон бусад холбогдох хууль тогтоомжид зохих өөрчлөлтийг оруулахаар төлөвлөж байна.

Дээрх бодлогыг амжилттай хэрэгжүүлсний дүнд бид 2009 онд эдийн засгийн өсөлт 2.75 хувиас бууруулахгүй барих төлөвлөгөөтэй байгаа бөгөөд инфляцийн түвшинг 2009 оны эцэст нэг оронтой тоонд хүргэх, төсвийн алдагдлыг ДНБ-ий 6 хувиас хэтрүүлэхгүй байх зорилт тавьж байна. Ингэснээр 2010 он гэхэд эдийн засаг сайжрах төлөвтэй болж, эдийн засгийн өсөлтийг 4.25 хувиас доошгүй байх, төсвийн алдагдлыг 4 орчим хувьд байхаар төсөөлж байгаа юм.

Засгийн газраас боловсруулсан хөтөлбөрийн урьдчилсан нөхцлүүдийг танилцуулъя. Эдгээр нөхцлүүдээс 2009 оны төсвийн тодотгол хийгдсэн, “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд нэмэлт оруулах тухай” хууль батлагдсан, татварын ерөнхий хуульд татварыг зөвхөн төгрөгөөр төлдөг болох өөрчлөлтийг оруулсан зэрэг гол ажлуудаа хийж гүйцэтгээд байна.

Бусад нөхцлүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөт ажлуудыг эхлүүлээд байгаа бөгөөд ойрын хугацаанд дуусгах болно.

Монгол Улсын Засгийн газрын энэхүү хөтөлбөрийн тухай дүгнэж хэлэхэд:

- Ойрын 18 сарын хугацаатай хөтөлбөр, түүнд тавигдсан зорилтуудыг хэрэгжүүлснээр Монгол Улсын санхүү, эдийн засгийн байдал тогтворжих,
- Дунд хугацаанд эдийн засгийн бүтцийг оновчтой болгох, төрөлжүүлэх арга хэмжээг хамтад нь авч хэрэгжүүлэх,
- Уул уурхайн салбарыг хөгжүүлэх, эдийн засгийн дархлааг сайжруулах суурь үндэс болж өгнө гэдэгт итгэлтэй байна.
- Хэдийгээр, дэлхийн ихэнхи орнууд санхүүгийн хүндрэлтэй байгаа ч манай бодлогыг дэмжих, тодорхой салбарт хамтран ажиллах түншүүд байна.

3. Дүгнэлт

Монгол Улсын эдийн засгийн өсөлт тогтворжино.

Эдийн засгийн бүтэц оновчтой болно.

Эдийн засгийн төрөлжилтийг баталгаажуулна.

Уул уурхайн салбарын хөгжил шинэ шатанд гаргах, “Толланд өвчин”-с сална.

Эдийн засгийн дархлаа сайжирч, мөчлөгийн хамаарлаас ангижирна.

	Balance of payments support and adjusted international reserves (US\$ million)		Budget deficit without financing (US\$ million)	
	2009	2010	2009	2010
Financing gap	157	67	145	60
OУВС/IMF	157	67	x	x
Дэлхийн Bank/World Bank			30	20
АХБ/ADB			30	20
Other partners				
Total support	157	67	60	40
Remaining gap	0	0	85	20

Төлбөрийн тэнцэл, валютын нөөцийг дэмжихэд зориулж 224 сая ам доллар олгох бололцоотой тухай ОУВС урьдчилан мэдэгдээд байгаа.

Харин энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад улсын төсвийн орлогын дутагдал, төсвийн алдагдлыг нөхөхөд зориулан 205 сая ам долларыг босгох шаардлага Засгийн газарт тулгараад байгаа болно.

Хямрал бэрхшээлийг өөрийн хүч бололцооны хэрээр даван туулахаар ажиллаж буй Засгийн газрын бодлого, байр суурийг дэмжиж ажиллахыг нийт түншлэгчид, Олон улсын санхүүгийн байгууллагын төлөөлөгчдөд уриалж байна.

Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссанаар бид дэлхий нийтийн хөгжлийн явцтай хөл нийлүүлэн явах бололцоотой болох бөгөөд олон улсын хамтын нийгэмлэгийн тэгш эрхэт гишүүн болох бололцоотой болох юм.